# ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН 2022 ОНЫ 05 ДУГААР САРД ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН

**2022.05.25** **Дархан-Уул аймаг**

## 1. ГАЗРЫН ХАРИЛЦААНЫ ЧИГЛЭЛ

**Газар зохион байгуулалтын төлөвлөлт, өмчлөлийн хүрээнд:**

Дархан-Уул аймгийн нутагт хэрэгжиж буй Газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөө, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийг хэрэгжүүлэх зорилгоор холбогдох хууль тогтоомж, Засгийн газрын тогтоол, шийдвэр, Барилга Хот Байгуулалтын болон Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргын тушаал шийдвэрийн дагуу ажиллаж байна.

Газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөг Газрын харилцаа, геодези, зураг, зүйн газрын даргын 2010 оны 11 дүгээр сарын 08 -ны өдрийн 497 дугаар аргачлалын дагуу төлөвлөгөөг боловсруулсан.

Уг арга зүйг баримтлан Дархан сумын 2022 оны тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг газар ашиглах, эзэмшүүлэх, өмчлүүлэх, иргэд олон нийтийн оролцоо, тэдний санал дээр үндэслэн жилийн хугацаатай төлөвлөгөө хэрэгжүүлэх нөхцөл бүрдэж байгаа юм.

Дархан-Уул аймгийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг Газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.2. дахь заалт, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.2. дахь заалтын дагуу Дархан-Уул аймгийн Дархан сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 28 дүгээр тогтоол, Орхон сум 2021 оны 12 дугаар сарын 16 ны өдрийн 10 дүгээр тогтоол, Хонгор сумын 2021 оны 12 дугаа сарын 13 ны өдрийн 16 дугаар тогтоол, Шарын гол сумын 2021 оны 12 дугаар сарын 10 -ны өдрийн 24 дугаар зэрэг тогтоолуудаар тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг батлуулж хэрэгжилтэнд хяналт тавих, хангах ажлыг зохион байгуулж ажиллав.

**<u>Газар зохион байгуулалтын төлөвлөгөө сурталчлах талаар:</u>**

Дархан-Уул аймгийн 2022 оны газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөг сурталчлах ажлыг байгууллагын www.darkhan.gazar.gov.mn цахим хуудас болон фэйс бүүк, www.Egazar.gov.mn цахим хуудсаар иргэн аж ахуйн нэгж байгууллагад ил тод нээлттэй сурталчлах ажлыг сар бүр зохион байгуулан ажиллаж байна.

Тухайн сард www.egazar.gov.mn цахим хуудаснаас 2021 оны тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсан байршлыг харах зааварыг орон нутгийн телевиз болох TV -12, RJB телевиз, DBS телевизээр иргэн, хуулийн этгээд, олон нийтэд мэдээллйг өгч ажилласан.






Зураг 1. Газар зохион байгуулалтын төлөвлөгөөг иргэдэд сурталчилсан

Газрын кадастрын мэдээллийн санд нөхөн бүрдүүлэлтээр оруулах шаардлагатай нэгж талбарын судалгаа гарган ажилласан. Дархан сумын нийт 18 багийн иргэн хуулийн этгээд болон төрийн байгууллагуудын 45 нэгж талбарын газар эзэмших цахим гэрээ, гэрчилгээг үүсгэн ажиллаа.



Зураг 2. Нөхөн бүрдүүлэлт

**<u>Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх чиглэлээр:</u>**

Дархан-Уул аймгийн хэмжээнд Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль хэрэгжиж эхэлсэнээс хойших хугацаанд өмчлүүлсэн газрын судалгааг гаргаж ажилласан.

Аймгийн хэмжээнд 2022 онд 445 иргэнд 35,05 га буюу хуучин эзэмшиж байгаа газрыг газрыг өмчлүүлэхээр төлөвлөсөн. Дархан сумд 1, 2, 3, 5, 6, 7, 8, Малчин багийн нутаг дэвсгэрт 195 иргэнд 65 га газрыг 2022 онд өмчлүүлэхээр батлагдсан.

Дархан сумын Засаг даргын захирамжийн төсөлд нийт 38 иргэний материалыг хүргүүлсэн.

**<u>Өмчлөх эрхээ бусад аймаг, орон нутагт хэрэгжүүлэхээр лавлагаа авсан иргэдийн судалгаа:</u>**

Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуульд өөрчлөлт орсноос хойш аймгийн хэмжээнд газар өмчлөх эрхээ бусад аймаг, орон нутагт хэрэгжүүлэхээр хүсэлт гаргасан 14 иргэнд лавлагаагаар үйлчилсэн байна.

**<u>Бусад ажил:</u>**

Аймгийн Цагдаагийн газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар болон Прокурорын газарт шалгагдаж байгаа иргэн, хуутгээдийн нийт 14 албан бичгийн лавлагааг мэдээллийн сан болон газар өмчлөх захирамжаас шүүж хариуг хүргүүлсэн.

## Геодези, зураг зүйн, кадастрын хүрээнд:

Хаягийн зургийн дагуу **11** иргэн, **10** аж ахуйн нэгжийн эзэмшлийн газар, үл хөдлөх эд хөрөнгөд хаяг дугаар олгосон.

Шинээр үл хөдлөх эд хөрөнгийн гэрчилгээ авахаар /хувийн сууц , гараж, барилга байгууламж/ хэмжилт хийлгэсэн **16** иргэн, **8** аж ахйн нэгжийн материалыг хүлээн авч мэдээлийн санд оруулж кадастрын зураг гаргасан.

Өмчлөх эрхээ бусдад шилжүүлэх хүсэлтээ цахимаар ирүүлсэн **9** иргэний материалыг хянаж өмчлөх эрхийг шилжүүлсэн.

Геодези, зураг зүй, кадастрын зураглалын ажил үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй "Гео од", "Ёлт сүрвэй" ХХК-ний хийж гүйцэтгэсэн

- Төвийн хатуу хучилттай авто зам улаан шугам
- Иргэн Ш.Дарханбатын бохирын шугамын гүйцэтгэл.
- 100-н хүүхдийн цэцэрлэгийн байр улаан шугам
- Онцгой байдлын газар өргөтгөлийн барилга улаан шугам
- “Хасвуу” ХХК-ний Бетон шонгийн үйлдвэрийн барилга гүйцэтгэл
- “Өгөөж чанар” ХХК-ний үйлчилгээтэй орон сууцны гүйцэтгэл
- 216-н айлын орон сууц 2-р блок гүйцэтгэл. зэрэг 17 ажлыг актаар хүлээн авсан.

GNSS-ийн байнгийн ажиллагаатай стацад тулгуурлан GPS-ийн сүлжээний 704, 5707, 012, 5480 цэгүүд дээр бодит агшины RTK хэмжилт хийж гүйцэтгэн хэмжилтийн үр дүнг 192.168.20.24 /Geodesy/ GNSS Дархан хавтсанд байршуулж, албан бичгээр хүргүүлсэн.

Цагдаагийн газрын мөрдөн байцаах тасагт шалгагдаж байгаа гэмт хэргийн бүртгэлийн 272, 606 дугаартай гомдол мэдээлэлд өгөгдсөн цэгийн байршлыг харуулсан зургийг гаргаж албан бичгээр хүргүүлсэн.

**Газрын төлбөрийн талаар:**

- 9-р багт 349 гаражийн мэдээлэл манай байгууллагын архивын мэдээллийн санд бүртгэлтэй байна. Үүнээс 4 иргэнд хугацаа сунгах тухай утсаар мэдэгдэж, 4 гэрээг нөхөн бүрдүүлж мэдээллийн санд оруулсан, 6 гэрээний кадастрын зураг байхгүй, байршил тодорхойгүй, утасны дугааргүй тул шинэчлэх боломжгүй байна.
- Газар өмчлөлийн 2070 нэгж талбарын хөрөнгийн бүртгэлийг нэг бүрчлэн аймгийн Татварын удирдлагын нэгдсэн системд илгээж, газрын татварын нэхэмжлэлийг үүсгэсэн.
- Газрын эрх зүйн харилцааг хянан шийдвэрлэх 2022.05.20-ны өдрийн хурлаар 43 иргэний гаражийн асуудлыг танилцуулж, захирамжийн төсөлд илгээлээ.
- Аймгийн хэмжээнд 2022.05.24-ний өдрийн байдлаар 231 барьцааны гэрээ бүртгэж, цахимаар төлбөрийн даалгавар үүсгэж төлүүлсэн байна. Үүнд: Дархан 94, Орхон 21, Хонгор 115, Шарын гол 1 барьцаа бүртгэсэн байна.
- Аймгийн хэмжээнд 8315 хүчинтэй гэрээнд ногдол үүсгэснээс 8241 гэрээнд 1.5 тэрбум төгрөгийн нэхэмжлэл үүсгэж Татварын удирдлагын нэгдсэн системд илгээсэн байна.

## 2. БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЧИГЛЭЛ

**Барилга хот байгуулалтын хүрээнд:**

Төвийн бүсийн барилга экспо-2022-г “Дархан-50” цогцолбор дээр 2022.05.28-29-ны өдрүүдэд 2 өдөр зохион байгуулахаар болсон. Энэхүү Экспод барилга бүтээн байгуулалт, барилгын материалийн үйлдвэрлэл, орон сууц, амины сууцны шинэлэг шийдлүүдийг оролцуулсан 40 аж ахуйн нэгж байгууллагуудыг оролцуулхаар бэлтгэж ажлыг хангасан. Үүнээс Улаанбаатар болон Эрдэнэт, Сэлэнгээс 12, орон нутгаас 28-н байгууллага оролцсон.

`

Барилгын хөгжлийн төвөөс Дархан-Уул аймгийн хэмжээнд 2022 онд ашиглалтад орсон болон 2022-2024 онуудад ашиглалтад орох нийтийн орон сууцны судалгаа ирүүлсэн маягтын дагуу хариуг албан бичгээр хүргүүлсэн.

✓ Засгийн газрын 213-р тогтоолын дагуу барилга ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрлийг 3 барилгад олгосон. Үүнд:

- Дэлгэрэх бат дэвжих ХХК-ний үйлчилгээний барилга
- Ган дизель ундарга ХХК-ний үйлчилгээний барилга
- Хонгор сумын 100 ортой хүүхдийн цэцэрлэгийн барилга

**Инженер, дэд бүтцийн хүрээнд:**

Хүргүүлсэн тайлан.

1. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт, МХГ-ын улсын ахлах байцаагчийн зөвлөмжийн хэрэгжилтийг гаргаж ХБТХОХ-т хүргүүлсэн.
2. ГЗБГЗЗГ-ын даргын албан даалгаварын хэрэгжилтийг гаргаж хүргүүлсэн.
3. Барилга хот байгуулалтын сайдын хэрэгжилтийг нэгтгэж ХБТХОХ-т хүргүүлсэн.

Засгийн газрын 213-р тогтоолын дагуу барилга ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрлийг 2 барилгад олгосон. Үүнд:

- Дархан-Уул аймгийн Хонгор сумын 1-р баг, иргэн Т.Наранчимэгийн жуулчны баазын цэвэр усны худгийн 6кВ цахилгаан дамжуулах шугам
- Орхон сумын 1-р баг иргэн Ж.Отгонбаатарын төмс, хүнсний ногооны усалгаатай тариалангийн зориулалттай газрын цахилгаан хангамж
- Орхон сумын 1-р баг иргэн К.Мягмарсүрэнгийн төмс, хүнсний ногооны усалгаатай тариалангийн газрын цахилгаан хангамж

АХБ-ны санхүүжилтээр хэрэгжиж буй MOH9206 төслийн Дархан суманд 5 байршилд дахивар бүтээгдэхүүн хүлээн чингэлэг байрлуулахтай холбоотой ажлыг төслийн багт танилцуулсан.

**Барилгын материал, үйлдвэрлэлийн чиглэлээр**

Барилгын материалын үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл СУНГУУЛАХ, НЭМЭЛТЭЭР хүссэн ААНБ-ууд нь бүтээгдэхүүн үйлдвэрлэл, үйл ажиллагааны тайлан мэдээг /Барилга, хот байгуулалтын сайд, Үндэсний статистикийн хорооны даргын хамтарсан 2019 оны 12 сарын 18-ны өдрийн 206, А/184 тоот тушаалын мэдээлэл авах холбогдох маягтаар /БМ-1, БМ-2/ тайлангаа хагас, бүтэн жилээр гаргаж ирүүлнэ гэсэн заалтын дагуу БАРИЛГЫН НЭГДСЭН МЭДЭЭЛЛИЙН СИСТЕМ-д ttps://license.mcis.gov.mn/login 2022.07.20-ны дотор цахимаар илгээх, мөн үйл ажиллагаа явуулаагүй бол үйл ажиллагааны “Х”-ээр ирүүлэх тухай мэдээллийг аймгийн ГХБХБГ-ын 2022.06.13-ны №376 тоотоор хүргүүлж мэдэгдсэн.


ДАРХАН-УУЛ АЙМАГ
ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА
ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗАР

2022.06.13 № 376

Иннова ложистик Х ...-д

Барилгын материалын тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж байгууллагууд үйл ажиллагааны тайлан мэдээг Барилга, хот байгуулалтын сайд, Үндэсний статистикийн хорооны даргын хамтарсан 2019 оны 206, А/184 дүгээр тушаалаар шинэчлэн баталсан маягт, маягт нөхөх зааврын дагуу хуулийн хугацаанд БАРИЛГЫН НЭГДСЭН МЭДЭЭЛЛИЙН СИСТЕМ-д https://license.mcis.gov.mn/login 2022.07.20-ны дотор цахимаар илгээнэ үү.

Нэвтрэх нэр, нууц үгийг мартсан болон шинээр авах бол 80100081, 99143628 утсаар холбогдож авна уу.

ДАРГА Д.БАТЧУЛУУН

D:\Tsendee\ 2022\албан тоот\toot A5.376.doc

Жич: Барилгын материалын түүхий эд олборлох, боловсруулах, түүгээр төрөл бүрийн материал, хийц эдлэлийн үйлдвэрлэл эрхлэгч нарт


БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛ, БОРЛУУЛАЛТЫН 2021 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ЭЦСИЙН МЭДЭЭ

I. ХАЯГИЙН МЭДЭЭЛЭЛ

| | | |
|---|---|---|
| Аж ахуйн нэгж, байгууллагын нэр | " " ХХК | |
| Регистрийн дугаар | | |
| **ААНБ-ын байршил** | Нэр | Код |
| Аймаг нийслэл | Дархан-Уул аймаг | |
| Сум, дүүрэг | Дархан | |
| **Үйлдвэрийн байршил** | Нэр | Код |
| Аймаг нийслэл | Дархан-Уул аймаг | |
| Сум, дүүрэг | Дархан | |
| Баг, хороо | ...-р баг | |
| Утас | 7037..... | |
| Гар утас | 99........ | |
| И-мэйл хаяг | @ | |
| Үйлдвэр байгуулагдсан он | 20....... | |
| Хариуцлагын хэлбэр | ХХК | 1 1 |
| Өмчийн хэлбэр | Хувийн | 2 1 |
| Үйл ажиллагааны чиглэл | Бүт | |

1. Аж ахуйн нэгж, байгууллага тайлант оны эхний хагас жилийн мэдээг 7 дугаар сарын 20-нд, жилийн мэдээг дараа оны 2 дугаар сарын 21-нд барилгын асуудал эрхэлсэн Төрийн захиргааны байгууллагуудад цахим хэлбэрээр ирүүлнэ.

2. Барилгын асуудал эрхэлсэн Төрийн захиргааны байгууллага тайлант оны эхний хагас жилийн мэдээг 7 дугаар сарын 25-нд, жилийн мэдээг дараа оны 2 дугаар сарын 25-нд Барилгын асуудал эрхэлсэн Төрийн захиргааны төв байгууллагад ирүүлнэ.

3. Барилгын асуудал эрхэлсэн Төрийн захиргааны төв байгууллага тайлант оны эхний хагас жилийн мэдээг 7 дугаар сарын 30-нд, жилийн мэдээг дараа оны 3 дугаар сарын 4-нд Үндэсний Статистикийн Хороонд ирүүлнэ.

Тус мэдээнд бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн тоо хэмжээ болон борлуулалтын үнийн мэдээ, ашиглагдаж буй машин механизм, ажилчдын тоо, олгосон цалин, Барилгачдын хөдөлмөрийн багаж ажлын хувцас, хэрэгсэлд зарцуулсан зардлын хэмжээ, Барилгын талбай дахь хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуй, аюулгүй ажиллагааг хангах зардал бүхий мэдээдэл багтана.

Өөрсдийн лабораторигүй учир аймгийн хэмжээний барилгын материалын шинжилгээг Улаанбаатар хот болон аймгийн ШУТИС-ийн дэргэд дэх барилгын материалын итгэмжлэгдсэн лабораторит шинжлүүлдэг. Дархан Төмөрлөгийн үйлдвэр шинжилгээ хийх 10 тоног төхөрөөмжтэй, харин ШУТИС-ийн дэргэдэх лаборатори нь 41 төрлийн шинжилгээний тоног төхөөрөмжтэй, бүх үзүүлэлтээр шинжилгээ гарахгүй. Иймд эдгээр лабораториудад бүтээгдэхүүний шинжилгээнд өгч, шаардлагатай тохиолдолд Улаанбаатар руу явуулж байна.

Барилгын материалын үйлдвэрүүд өөрсдийн лабораторид өдөр тутмын бүтээгдэхүүнд шинжилгээ хийхээс гадна ШУТИС-ийн дэргэдэх Барилгын материалын сорилтын лабораторид дээж өгч шинжлүүлж ажилладаг. 2022 онд аймгийн 12 үйлдвэрийн 8 нэр төрөл дээр 23 удаагийн гадаад шинжилгээ хийж дүгнэлт гарсан болно.

**Барилгын Материалын Сорилтын лабораторид**
**2022 оны 01 -р сарын 02-ээс -р 06 сарын 10 хүртэл хийгдсэн шинжилгээ**

Байгууллагын цахим хуудас болон Фэйсбүүк хуудсан дээр Газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны талаарх мэдээлэл, Эх үрсийн баярын мэндчилгээ, Эх үрсийн баяраар зохион байгуулсан арга хэмжээний талаарх мэдээ байрлуулав.

Эх үрсийн баярын мэндчилгээний постер, эх үрсийн баяраар зохион байгуулах тэмцээний ялагчид өгөх дурсамжийн эхийг бэлтгэж, хэвлэж өгөв.

Серверийн өрөөний кондишны илүүдэл усыг 1 асгаж цэвэрлэв. Хонгор сумын газрын даамал Ц.Базарсадын компьютерийг форматлаж, үйлдлийн систем, бусад хэрэглээний програмуудыг суулгаж, хэвлэгч, сканерыг таниулж, VPN холболтын тохиргоог хийж өгөв.  Кадастрын мэргэжилтний компьютерт хэрэглээний програм суулгаж өгөв.







## Нярав:

10 ширхэг Нэгж талбарын хувийн хэрэг нугалж мэргэжилтнүүдэд олгоход бэлтгэв. Газрын удирдлагын хэлтсийн мэргэжилтнүүдэд 4 ширхэг нэгж талбарын хувийн хэргийн хавтас олгож, кадастрын мэдээллийн санд өөрчлөлт оруулсны төлбөрийн баримт 40 ширхэгийг хүлээж авч бүртгэв.

Шаардах хуудсаар 4 төрлийн 5.5 ширхэг бараа материал олгов.

## Өргөдөл гомдол шийдвэрлэлтийн талаар:

- ГХБХБГ-т 2022 оны 5 сарын 23-ны өдрөөс 6 сарын 24-ний өдрийн хооронд Абле программд нийт 141 албан бичиг /хариутай 107/, 38 өргөдөл /хариутай 28/ ирсэнээс 81 албан бичиг, 19 өргөдөл шийдвэрлэн, 62 албан бичиг, 9 өргөдөл хяналтанд бүртгэжээ.

*Албан бичиг, өргөдлийн шийдвэрлэлтийг графикаар харуулбал:*

**График 1. Албан бичиг, өргөдлийн шийдвэрлэлт, хяналтанд авч судлаж буй талаарх мэдээлэл**







- Мөн Egazar.gov.mn системээр 204 өргөдөл хүсэлт хүлээн авсан бөгөөд тус системийн шийдвэрлэлтийн тайлан гаргадаг цэс нь одоогоор ажиллахгүй байгаа тул шийдвэрлэлтийн дүнг гаргах боломжгүй байна.

**БОЛОВСРУУЛСАН:**

ЗАХИРГАА, ХУУЛИЙН АСУУДАЛ
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН Б.ЗОЛБАЯСАХ

**ХЯНАСАН:**

ГАЗРЫН УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН ДАРГА Г.НЯМДОРЖ